

ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

2011.03.11

Сүхбаатар

Нэг. Монгол Улсын Шадар сайдад:

Мэргэжлийн хяналтын чиглэлээр: 5 бүтээгдэхүүнийг 80 хувийн гүйцэтгэлтэйгээр нийлүүллээ.

Аймгийн нутаг дэвсгэрт 28 салбар чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулж, 4037 зөрчлийг илрүүлэн 63795.5 мянган төгрөгийн нөхөн төлбөр, 4158.7 мянган төгрөгийн торгууль шийтгэврийн арга хэмжээ авч ажилласан.

Мэргэжлийн хяналтын байгууллагын шинэчлэл нээлттэй өдөрлөгийг аймгийн хэмжээнд зохион байгуулж, 21 улсын байцаагч, 188 иргэн, 37 аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлж, эрх зүйн зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан.

Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр: 4 ангийн 10 бүтээгдэхүүнийг нийлүүлж, 93.7 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа.

Үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хүүхдийг хөгжүүлэх, хүүхдийн оролцоог хангах, хүүхдийг эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх, нийгмийн суурь үйлчилгээгээр хангах, гэр бүлийг дэмжих, хамгаалах үйлчилгээг жигд хүргэж нийт 83.0 сая төгрөгийг зарцууллаа.

Аймгийн “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн “Сумдын Хүүхдийн төлөө зөвлөлүүдийн үйл ажиллагааны талаархи мэдээлэл”, “Насанд хүрээгүй хүүхдийн гэмт хэргийн байдал, цаашид анхаарах асуудал”-уудыг хэлэлцэн шийдвэр гарган хэрэгжилтийг ханган ажиллалаа. “Хүүхдийн хөгжил хамгаалал”-ыг сайжруулах /2008-2010/ аймгийн дэд хөтөлбөрийн 3 дахь шатны тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, хөтөлбөрийн хэрэгжилт 87.0 хувьтай дүгнэгдлээ. Дэлхийн Зөн монгол Олон Улсын байгууллагын Сэлэнгэ нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран аймгийн хүүхдийн “Хөгжилд хүүхдийн оролцоо” III чуулганыг зохион байгуулж, 140 төлөөлөгч чуулж, хүүхдүүдийн өмнө тулгамдаж байгаа асуудлаа хэлэлцэж, чуулганаас уриалга гаргаж, аймаг, сумдын удирдлагуудад хүргүүлээ.

Онцгой байдлын чиглэлээр: 4 бүтээгдэхүүнийг 1192755.4 мянган төгрөгийн санхүүжилтээр 93 хувийн гүйцэтгэлтэйгээр нийлүүллээ.

Гамшгийн эмзэг байдал, эрсдийн үнэлгээг 45 аж ахуйн нэгж байгууллагад хийж, аймгийн хэмжээнд гал түймрийн тоог 20 хувиар, учирсан хохирлын хэмжээг 8.3 дахин бууруулж, гамшгийн үед шуурхай удирдлагаар хангах хөдөлгөөнт удирдлагын 2 байрыг 3.8 сая төгрөгийн өөрийн хөрөнгөөр хийсэн.

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг Онцгой байдлын ерөнхий газраас ирүүлсэн зааврын дагуу бэлтгэл бэлэн байдлын бүрэн хангаж, 11-р сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулж “Дүүрэн хангалттай” үнэлгээтэйгээр дүгнэгдэж, арга хэмжээнд аймгийн Гамшгаас хамгаалах 12 алба, тусгай зориулалтын болон ерөнхий зориулалтын 8 мэргэжлийн ангийн 635 хүн оролцсоны дээр, 17 сумын гамшгаас хамгаалах бүрэлдэхүүн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин “Газар хөдлөлт, “Хүн малын

гоц халдварт өвчинтэй тэмцэх” цагийн байдлууд дээр ажиллаж хүн эмнэлэг, мал эмнэлгийг тус тус дэлгэж, Төмөр замын Сүхбаатар зангилаа, орон сууцны барилга дээр газар хөдлөлтийн гамшгийн үзүүлэх сургуулийг зохион байгуулсан.

Хоёр.Батлан хамгаалахын сайдад:

4 бүтээгдэхүүн ангийн 16 нэр төрлийн бүтээгдэхүүнийг 97.0 нийлүүллээ.

Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг орон нутагт сурталчлах, Зэвсэгт хүчний 89 жилийн ой, Аугаа их ялалтын 65 жилийн ойн арга хэмжээ, БНХАУ-ын АЧА-ны Жанжин штабын дэд дарга тэргүүтэй төлөөлөгчдэд үзүүлэх бэсрэг наадам, дайчилгааны бэлтгэл нөөцөөс сонгон авсан 20 бэлтгэл офицер, 50 бэлтгэл үүрэгтэнтэй явуулах 10 хоногийн давтан сургалтыг тус тус зохион байгууллаа.

Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл, Цэргийн насны залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, тоо бүртгэлд 18-50 насны бүх эрчүүдийн 97.1 хувь хамрагдлаа.

Гурав.Хууль зүй, дотоод хэргийн сайдад: тайлант онд байгуулсан гэрээний дагуу Удирдлага зохион байгуулалтын 8, Гэмт хэрэгтэй тэмцэх 7, нийгмийн хэв журам сахиулах 6, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 12, Тусгай захиалгат 5, Өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх 2, нийт 3 ангийн 40 нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлж орон нутгийн санхүүжилтээр 218.3 сая төгрөг, улсын төсвийн санхүүжилтээр 1539517.3 төгрөгийн санхүүжилт олгуулж тайлан мэдээг сар, улирлаар гаргуулан ажиллаа.

Удирдлага зохион байгуулалтын 8 бүтээгдэхүүний биелэлтийн дундаж хувь 100, гэмт хэрэгтэй тэмцэх 7 бүтээгдэхүүний биелэлтийн дундаж хувь 98, нийгмийн хэв журам сахиулах 6 бүтээгдэхүүний биелэлтийн дундаж хувь 100, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 12 бүтээгдэхүүний биелэлтийн дундаж хувь 100, тусгай захиалгат 5 бүтээгдэхүүний биелэлт 100 хувь, өмчлөгчийн эрхийг шилжүүлэх 2 бүтээгдэхүүний биелэлт 100 хувь гэрээний бүтээгдэхүүний нийлүүлэлт 99.3 хувийн дундаж биелэлттэй байна.

Аймгийн хэмжээнд 2010 онд 797 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2009 оныхоос 17 хэрэг буюу 2.0 хувиар буурлаа.

Бүртгэгдэх үедээ эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 197 хэргээс 133 хэргийн холбогдогчийг тогтоож илрүүлэлт 67.5 хувьд хүрсэн нь 2009 оныхоос 4.1 хувь өссөн үр дүнтэй байна.

Гэмт хэргийн илрүүлэлтийг хэргийн ангиллаар авч үзвэл хөнгөн гэмт хэргийнх 66.6, хүндэвтэр гэмт хэргийнх 67.6, хүнд гэмт хэргийнх 66.67, онц хүнд гэмт хэргийнх 100 хувьтай байна.

Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд 837.3 сая төгрөгийн хохирол учирснаас 594.4 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн нь хохирол төлүүлэлт 71 хувьтай байна.

Гэрээнд туссаны дагуу улсын төсвийн 102 сая төгрөгийн хөрөнгөөр Баруунбүрэн суманд, аймаг орон нутгийн нөөц бололцоог дайчилсан 170 сая хөрөнгөөр Хушаат, Түшиг суманд цагдаагийн кабоны байрыг шинээр бий болгосон.

Цагдаагийн бие бүрэлдэхүүн, алба хаагч нарын ажлын байрны нөхцлийг сайжруулах ажлын хүрээнд цагдаагийн газрын конторын барилгын 31 цонхыг вакум цонхоор шинэчлэн солиулах ажил хийгдэж,

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар “Нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” аймгийн хөтөлбөрийг батлуулсны дээр “Архи согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээнд хязгаарлалт тогтоох тухай” захирамж зэрэг бодлогын шийдвэрийг гаргаж хэрэгжилтийг хангуулан ажиллаа.

Дөрөв.Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдад: 4 бүлэг бүтээгдэхүүнийг 95.3 хувиар нийлүүлж, Боловсрол соёлын салбарын 95 байгууллагад 15.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг цаг хугацаанд нь бүрэн олголоо.

Цэцэрлэгийн 91 хувь, ерөнхий боловсролын сургуулийн 94.2 хувь нь “Багш хөгжлийн төв”-тэй болж, цэцэрлэгийн мэргэжлийн багшийн хангамж 84.6 хувь, ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангамж 98.4 хувьд хүрч, мэргэжил дээшлүүлэх сургалтанд давхардсан тоогоор 2879 багш, удирдах ажилтныг хамрууллаа.

Суурь боловсролын хамран сургалт 98.5 хувьд хүрч, өмнөх оныхоос 0.1 хувиар, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 96.5 хувьд хүрч, өмнөх оныхоос 13.2 хувиар ахисан байна.

Нийт 2434 суралцагчид гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамрагдаж, 221 секц, дугуйланд 7607 хүүхэд, сэтгэх чадвар IQ-г хөгжүүлэх дугуйланд 2022 суралцагч, шатрын дугуйланд 342 хамрагдаж, хүүхдийн авьяас чадвар, сэтгэхүй хөгжих таатай боломж бүрдлээ.

1-5-р ангийн 9602 хүүхэд “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдаж, 601020.3 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж, Сургууль, цэцэрлэгт 1329 компьютер ашиглаж, 27 сургууль, 11 цэцэрлэг интернэтэд холбогдлоо.

Боловсролын салбарт 2524.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.

Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио” чуулга, Дуу бүжгийн “Мөнгөн хараа чуулга” нь 2010 онд нийт 310 урлагийн тоглолт, соёлын арга хэмжээ зохион байгуулж 74243 хүнийг хамруулан 22.9 сая төгрөгийн орлого оруулж, шинээр 3 уран бүтээл туурвисан бөгөөд Төрийн шагналт, Ардын уран зохиолч, Соёлын гавъяат зүтгэлтэн Б.Лхагвасүрэнгийн зохиол “Буур хээрийн домог” дуулалт бүжгэн жүжгийг Төрийн соёрхолт, Соёлын гавъяат зүтгэлтэн С.Сүхбаатар найруулж үзэгчдийн хүртээл болголоо.

Мэргэжлийн урлагийн байгууллагын шинэ уран бүтээл, хөгжим, техник хэрэгсэл, тайзны засал, тоглолтын хувцас, гэрэлтүүлэг, засвар үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 88.823.4 сая, улсын төсвөөс 41.771.1 сая төгрөг, соёлын төвд нийт 149982.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийдлээ.

Нийтийн номын санд “Цахим ном”-ын танхим байгуулан тохижуулж интернэт сүлжээнд холбон номын санчдын ур чадварт түшиглэн бүртгэл мэдээллийг түргэн шуурхай олж авах эх суурь болсон электрон хэлбэрт шилжүүлэн электрон каталог, мэдээллийн архив цахим номын санг бий болголоо.

Аймгийн нэгдсэн музей нь 2429 хүнд үйлчилж, 1.575.5 мянган төгрөгийн орлого оруулж, аймгийн нутаг дэвсгэр дэх 25 төрлийн 1786 ширхэг түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг тоолж бүртгэн баримтжуулж, бүртгэл мэдээллийн санг 45 хувиар баяжууллаа.

Тав.эрүүл мэндийн сайдад: 9 бүлэг бүтээгдэхүүнийг 98.0 хувь нийлүүлж, салбарын 34 байгууллагад 5724970.6 мянган төгрөгийн санхүүжилтийг цаг хугацаанд нь бүрэн олголоо.

2010 онд 1896 эх төрж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1000 хүн амд ногдох төрөлт 0.2 промилээр өсч, 1909 амьд хүүхэд төрж, 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 16, 1-4 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 8 тохиолдолд тус тус

бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1000 амьд төрсөн хүүхэд тутамд 3.7 промилээр буурч, Халдварт өвчин 2010 онд 10.000 хүн амд 103 ногдож, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 27.5 хувиар буурсан.

Улсын төсвийн 348.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сант суманд 10 хүний ортой хүн эмнэлэг ашиглалтанд орсон. Эрүүл мэндийн салбарт Улс, орон нутгийн болон төсөл хөтөлбөрийн шугамаар 124760.7 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.

Зургаа.нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдад: 5 бүтээгдэхүүнийг 99.3 хувийн гүйцэтгэлтэй нийлүүлж, Хүний хөгжил сангаас иргэн бүрт хувь хишиг хүртээх ажлын хүрээнд 104107 иргэнд 10421331.6 мянган төгрөгийг олгож, хувь хишиг хүртээх ажил 80 хувь, Халамжийн тэтгэвэрт 2497 иргэнд 1294512.2 мянган төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 796 иргэнд 238384.3 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөнгөлөлтөнд 554 иргэнд 102623.9 мянган төгрөг, алдарт эхийн 1,2-р зэргийн одонтой 5365 эхэд 662500.0 мянган төгрөг, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжинд 2886 эхэд 609436.0 мянган төгрөг, 17 ахмад дайчинд 40800.0 мянган төгрөг, алдар цолтой 108 ахмадад 99975.5 мянган төгрөгийн хөнгөлөлтийг үзүүлж ажиллалаа.

Энэ онд 2106 шинээр ажлын байр бий болгож, шинэ ажлын байрны 8.3 хувь нь төсөвт байгууллагад, 91.7 хувь нь хувийн хэвшилд бий болсон.

Улсын хөрөнгө оруулалтаар 350.0 сая төгрөгийн өртөгтэй Сүхбаатар сумын ахмадын сувиллын барилгыг ашиглалтанд оруулж ажиллалаа.

2010 онд нийгмийн даатгалын санд 10435.0 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулахаас 11372.2 сая төгрөгийн шимтгэл оруулж шимтгэлийн төлөвлөгөөг 109 хувиар, тэтгэврийн даатгалын санд 6416.8 сая төгрөг хуримтлуулахаас 6973.0 сая төгрөгийг оруулж төлөвлөгөөний биелэлт 108.6 хувь, тэтгэмжийн даатгалын санд 459.4 сая төгрөг хуримтлуулахаас 505.7 сая төгрөгийн шимтгэл хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 110 хувь, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд 826.7 сая төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлуулж, төлөвлөгөөний биелэлт 124 хувьтай, эрүүл мэндийн даатгалын санд 258.7 сая төгрөгийн шимтгэл хуримтлуулж, төлөвлөгөөний биелэлт 105.3 хувьтай, ажилгүйдлийн даатгалын санд 492.2 сая төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 110 хувиар тус тус биелсэн байна.

Шинээр шимтгэл төлөгч 35 ажил олгогч энэ онд хамруулахаас 93 ажил олгогч, шинээр заавал даатгалд 175 даатгуулагч даатгуулахаас 327 даатгуулагч, шинээр сайн дурын даатгалд 100 даатгуулагч хамруулахаас 141 даатгуулагч, эрүүл мэндийн даатгалд 1502 даатгуулагч хамруулахаас 1775 даатгуулагч хамруулан ажиллалаа.

Долоо.Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад: 4 ангийн 4 бүтээгдэхүүнийг 100 хувьтай биелүүлж ажиллалаа.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр “Гол мөрний сав газрын зөвлөл”-ийг шинэчлэн баталлаа. “Сэлэнгэ мөрөн”-ий сав газарт Зүүнбүрэн, Хушаат, Цагааннуур, Түшиг, Баруунбүрэн, Сүхбаатар сумдыг, “Орхон гол”-ын сав газарт Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Сант, Хушаат, Сайхан, Шаамар, Сүхбаатар сумдыг, “Ерөө гол”-ын сав газарт Ерөө, Жавхлант, Шаамар сумдыг, “Хараа гол”-ын сав газарт Мандал, Баянгол, Сайхан сумдыг хамруулан нутаг дэвсгэрийн усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх замар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааг дэмжин, хэрэгжилтийг хангахаар үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

2010 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ойг нөхөн сэргээх ажлыг 790 га-д, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр 700 га-д, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг 90 га-д хийж, намрын тооллогоор амьдралт 77 хувьтай байна.

Улсын төсвийн 6.0 сая төгрөгийн хөрөнгөөр Алтанбулаг сумын “Оргидог булаг”, “Гүн нуур”, Түшиг сумын “Ухмалын булаг”-т булаг усны эхийг хашиж хамгаалах ажлыг хийгдээд байна.

Найм.Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдад: 7 төрлийн бүтээгдэхүүнийг 96.0 хувийн

биелэлт нийлүүлээ. Үүнээс томоохон ажил арга хэмжээнээс онцлон дурьдвал:

Мандал, Баянгол, Сайхан, Алтанбулаг, Сүхбаатар сумдад тус бүр 20-н айлын орон сууц баригдах газрыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр нийт 2.27 га газрыг Орон сууц санхүүжилтийн корпорацид эзэмшүүлсэн.

Аймгийн нутаг дэвсгэрт геодезийн байнгын цэг, тэмдэгтийн нарийвчилсан судалгаа, тооллогын ажлыг мэргэжлийн эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй “Содсүрвэй” ХХК, “Монмет инженер” ХХК, “Геокад” ХХК-уудаар гүйцэтгүүлсэн бөгөөд, дээрх компаниудтай сумдын газрын даамлууд хамтран ажилласан.

Барилгын үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, компаниудтай гэрээ хийж, хяналт тавин ажиллаж байна. Давхардсан тоогоор 46 компанитай хяналтын гэрээ байгуулж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 134-р тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2010 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 18 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд 2010 онд иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээг 3878,05 га-гаар тогтоож, үүнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа иргэнд өмчлүүлэх 1977,99 га, аж ахуйн зориулалтаар 1900,06 га-гаар олгохоор шийдвэрлэснээс 2010 онд аймгийн хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нийт 1906 иргэнд 376 га- газрыг өмчлүүлсэн. Газар өмчлөлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд нийт 14080 иргэнд 3672.94 га газрыг өмчлүүлсэн дүнтэй байна.

Ес.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад: 5 бүтээгдэхүүний 48 арга хэмжээ төлөвлөгдөж 94.0 хувьтай биелүүлж ажиллаа.

2010 онд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээ 2009 оныхоос 5 хувиар Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээ 20.3 хувиар тус тус өсч, ажлын байр 200 гаруй хүнээр нэмэгдсэн.

Аймгийн хэмжээнд 2.1 мянган адуу, 22.0 мянган үхэр, 66.0 мянган хонь, 21.5 мянган ямаа бүгд 111.6 мянган мал цөм сүрэгт бүртгэгдсэн

2010 онд 143895.6 га талбайд тариалснаас үр тариа 129575.2 га-гаас 17478,5 тн үүнээс буудай 125250.7 га-гаас 170888 тн, арвай 3063.4 га-гаас 2086,4 тн, овьёос 1206.2 га-гаас 1036,2 тн, гурвалжин будаа 5 га-гаас 7,5 тн, бог будаа 50 га-гаас 60 тн, тэжээлийн ургамал 1485.2 га-гаас 8203 тн, техникийн ургамал 12835.1 га-гаас 5966,7 тн, төмс 2907,3 га-гаас 45401 тн, хүнсний ногоо 1801,7 га-гаас 30286,5 тн ургац хураан авч өмнөх оныхоос үр тариа 10,8, төмс 2,8, хүнсний ногоо 1 хувиар тус тус өссөн байна.

2010 онд 4123 га-гаас 10 000 тн үр тариа, 2907,3 га-гаас 45401 тн төмс, 1801,7 га-гаас 30286,1 тн хүнсний ногоо хураан авч, усалгаатай газар тариалангийн талбайн өмнөх оныхоос 8,9 хувиар нэмэгдсэн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний тэргүүлэгчдээр “Хүнсний баталгаат байдал” аймгийн дэд хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, “Хоршоог хөгжүүлэх Сэлэнгэ аймгийн хэмжээний хөтөлбөр”-ийг тус тус батлуулан хэрэгжүүлж байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙН НЭГТГЭЛ**

2011.03.11

№	Салбарын нэр	Бүтээгдэхүүний тоо	Нийт хувь
1	Монгол Улсын Шадар сайд	3	88.9
2	Батлан хамгаалахын сайд	16	97.0
3	Хууль зүй, дотоод хэргийн сайд	40	99.3
4	Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд	4	95.3
5	Эрүүл мэндийн сайд	9	98.0
6	нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	5	99.3
7	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	4	100
8	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд	7	96.0
9	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	5	94.0
НИЙТ			96.4

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР